

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны
 12 дугаар сарын 27-ны өдрийн 14:00
 дугаар тушаалын хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27 14:00

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Цагдаагийн ерөнхий газар

Алба, харьяа нэгжийн Мөрдөн шалгах хэлтэс,
 тасаг

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Чиглэлийн ахлах мөрдөгч

ТТ-4

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

8 цаг

Алба, нэгжийн цагдаагийн
 байгууллагын байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Байгалийн гамшиг, гол түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд уртасгасан цагаар болон өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан Улсын ерөнхий прокурорын газар, Нийслэлийн прокурорын газраас харьяалал тогтоосон гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, шийдвэрлэх, мөрдөгчдийн ажлын хэсэг ахлах, ажлын хэсэгт ажиллах, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох ажиллагааг зохион байгуулах, хэлтсийн даргын эзгүйд албан үүргийг түр орлон гүйцэтгэх, нэгжүүдийн мөрдөгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах.

1.Харьяалах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу хэрэг бүртгэлт, мөрдөн

байцаалтын ажиллагаа явуулах, ажлын хэсэг удирдан, мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллах.

2.Гэмт хэрэг, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох, мөрдөн шалгах ажиллагаа явуулах талаар цагдаагийн бусад албадтай хамтран ажиллах.

3.Удирдлагаас өгсөн үүргийн дагуу даалгасан ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх.

4.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах -Т, Харилцан, гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Монгол Улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны холбогдох журамд заасныг хэрэгжүүлэх; 1.2.Мөрдөн байцаах албаны даргын тушаалаар батлагдсан дүрэм, журам, зааврыг хэрэгжүүлж ажиллах. 1.3.Гэмт хэргийн бодит байдлыг тогтоох, гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг эрэн сурвалжлах, олж тогтоох	Мөрдөн байцаалтын ажлын үр дүн дээшилж, гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтэд тодорхой үр дүн гарсан байна.	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 229/-ыг хэрэгжүүлэх; 2.2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх; 2.3.Ахлах мөрдөгч, мөрдөгч, дуудлагын цагдаа нарын ажлын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах; 2.4.Удирдлагаас хуваарилсан олны анхаарал татсан онцлог зарим гэмт хэргийг илрүүлэх, нотлох ажиллагааг хэрэгжүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах.	Хамтын ажиллагаанд ахиц, үр дүн гарсан байна.	Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Удирдлагаас өгсөн үүргийг цаг тухайд нь биелүүлж, үр дүн биелэлтийг тооцож танилцуулах. 3.2.Шаардлагатай тохиолдолд хэлтэс, тасгийн даргын эзгүйд Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт заасны дагуу албан үүргийг түр орлон гүйцэтгэх;	Хуулиар хүлээлгэсэн нийтлэг чиг үүргийн биелэлт хангагдана.	Г
Хууль тогтоомж,	4.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын	-	Г

дүрэм журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх	<p>ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид, иргэдтэй зөв боловсон харьцах, ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх;</p> <p>4.2. Авлига, хүнд суртлаас анgid байж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн шударга ёсыг эрхэмлэн, "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд мөрдөх;</p> <p>4.3. Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.</p>		Г Г
---	--	--	--------

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд боловсролтой, бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	-Эрх зүй /0421/ -Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/		
Мэргэшил	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.		
Туршлага	Цагдаагийн байгууллагад 8-аас доошгүй жил, үүнээс харьяа нэгжийн болон албаны ахлах, түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> -Хариуцсан ажлаа төлөвлөх, зохион байгуулах; -Удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдах чадвартай; -Албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, зохих заавар чиглэл өгөх. 	
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> -Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулж, дүгнэх; -Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг дүгнэх. 	
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> -Албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх . 	
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> -Ес зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дууриал үзүүлэх; -Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; -Байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх. 	
	Бусад	<ul style="list-style-type: none"> -Албан хэрэг хөтлөлт боловсруулах, монгол хэл, бичгийн дүрэм, уг зүй, найруулга зүйн зохих мэдлэгтэй байх. -Компьютерийн Microsoft Office Word, Microsoft Office Excel, Microsoft Office Power Point программуудыг хэрэглээний түвшинд ашиглах чадвартай байх. -Нууц хадгалах. 	

IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЬЕКТ

Албан тушаалд шууд харьялан удирдах албан тушаалын нэр:	Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:
	Алба, харьяа нэгжийн Мөрдөн шалгах хэлтэс, тасгийн дарга
Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	<p>Бусад харилцах субъект: Шууд харилцах байгууллага: -Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан;</p> <p>Шууд бус харилцах байгууллага:</p>

	-Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн; /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, ўйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.
--	--

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА Т.ГАНЗОРИГ 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: Байгууллагын нэр: Шийдвэрийн огноо: Дугаар:.....
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан: Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27-өдөр Дугаар: ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА	
T.СҮХБОЛД 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр	

ТАНИЛЦСАН:
Албан тушаалтан:
20... оны дугаар сарын-ны өдөр